



ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

№ А1-01/2019 /А-13/24

2019 оны ...-р сарын-ны өдөр

Нэг талаас "Диспетчерийн үндэсний төв" ХХК-ийг төлөөлж Арилжаа, санхүү эрхэлсэн дэд захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Бүрэнтогтох /цаашид "Худалдан авагч" гэх/ нь "Нэг худалдан авагчтай загвар"-ын хүрээнд "ДЦС-2" ТӨХК-аас диспетчерийн зохицуулалтаар үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг худалдан авч, арилжааны үйл ажиллагааг удирдан явуулах, диспетчерийн зохицуулалт хийх, нөгөө талаас "ДЦС-2" ТӨХК-ийг төлөөлж Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Мягмаржав /цаашид "Худалдагч" гэх/ нь диспетчерийн зохицуулалтанд хамрагдаж, диспетчерийн батлагдсан горимыг чанд мөрдөж, стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчийг Худалдан авагчид худалдахаар энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Худалдан авагч нь цахилгаан эрчим хүчний зах зээлийн "Нэг худалдан авагчтай загвар"-ын хүрээнд эрчим хүчний үйлдвэрлэлийг эдийн засгийн үр ашигтай хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн үйлдвэрлэлийн оновчтой горимыг тогтоож, үйлдвэрлэл хэрэглээг тэнцвэржүүлэн Нэгдсэн сүлжээний диспетчерийн болон арилжааны зохицуулалтыг хийж, Худалдагчийн нэгдсэн сүлжээнд нийлүүлсэн ЦЭХ-ийг худалдан авч, төлбөрийг "Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данс" /ТҮОНД/-аар төвлөрүүлэн барагдуулах, Худалдагч нь диспетчерийн батлагдсан горимыг чанд мөрдөж, Нэгдсэн сүлжээний найдвартай тогтвортой, тасралтгүй ажиллагааг хангасан, техник технологийн шаардлагын дагуу үйлдвэрлэл явуулж, стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчийг Худалдан авагчид худалдах талаар харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлоход гэрээний зорилго оршино.
- 1.2. Талууд Монгол улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэмжлийн нэгдсэн байдлыг хангах тухай хууль, ЭХЗХ-оос баталсан үнэ тариф, Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм, Нэгдсэн сүлжээний дүрэм, Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Аюулгүй ажиллагааны дүрэм, Цахилгааны спот зах зээлийн дүрэм, Цахилгааны өрсөлдөөнт зах зээлийн дүрэм, Диспетчерийн графикайн биелэлт дүгнэх журам, Импортын графикайн хазайлтыг тооцох журам, Шуурхай ажиллагааны заавар, Нэгдсэн сүлжээний 2019 оны үйлдвэрлэл хэрэглээний балансын төлөвлөгөө болон бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллана.
- 1.3 Гэрээний хавсралт №1-д гэрээ дүгнэх актын загвар, хавсралт №2-д 2019 онд "ДҮТ" ХХК-д худалдах ЦЭХ-ний төлөвлөгөө, төсөв, хавсралт №3-д арилжааны заагийн цэгийг тодорхойлсон схем, хавсралт №4-д Худалдагчийн арилжааны цэг дэх тоолуурын жагсаалтыг тус тус хавсаргав. Худалдах ЦЭХ-ний тарифыг ЭХЗХ-оос баталсан тогтоолын дагуу тухай бүр өөрчлөн тооцно. Эдгээр хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний хамтаар хүчин төгөлдөр байна.

